



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/432

Булган сум

**“Идэвхтэй насжилт-Дасгал хөдөлгөөн”
улирлын аяныг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10, 11 дүгээр зүйлийн 11.1.2, 14 дүгээр зүйлийн 14.5.2, 14.5.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.1.8 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 01/1476 дугаар бичгийн дагуу ахмад настныг идэвхтэй хөдөлгөөн, дасгал, гүйлт зэрэг биеийн тамираар тогтмол хичээллэх, эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэхээр “Идэвхтэй насжилт-Дасгал хөдөлгөөн” улирлын аяныг 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2026 оны 11 дүгээр сарыг дуустал аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулсугай.

2. Тус аяныг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, нээлт болон хаалтын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус аяныг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

4. Аян зохион байгуулахад шаардагдах хөрөнгө болох 1,538,000 (нэг сая таван зуун гучин найман мянга) төгрөгийг Аймгийн Засаг даргын 2026 оны Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын, Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, хөгжил оролцоог дэмжих арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д. ПҮРЭВ-ОЧИР



6326010569

2026 өдөр бүр 2026 Захирамж

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 16 ны/ний өдрийн
А/432 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



УЛИРЛЫН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ
ТОМИЛОХ ТУХАЙ

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)
- Гишүүд: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Ц.Цолмонбаатар (Боловсролын газрын дарга)
Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
А.Ширчиндорж (Аймгийн Ахмадын холбооны тэргүүн)
- Нарийн бичгийн дарга: Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 16-ны/ний өдрийн
А/102 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**“ИДЭВХТЭЙ НАСЖИЛТ-ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨН” УЛИРЛЫН АЯНЫ НЭЭЛТ,
ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)
1	2	3	4	5
1	Тайзны хулдаасан хэвлэл (4*3 хэмжээтэй)	1	200,000	200,000
2	Цэвэр ус (12ш)	6	18,000	108,000
3	Медаль	18	10,000	180,000
4	Өргөмжлөл	4	50,000	200,000
5	Гар бөмбөгийн тэмцээний 1 дүгээр байр	1	300,000	300,000
6	Гар бөмбөгийн тэмцээний 2 дугаар байр	1	200,000	200,000
7	Гар бөмбөгийн тэмцээний 3 дугаар байр	1	150,000	150,000
8	Улирлын аяныг амжилттай зохион байгуулсан сумын урамшуулал	1	200,000	200,000
Нийт дүн				1,538,000

--o00o--